



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Хөдөө аж ахуйн их сургууль,
Магистр, докторын сургууль

Хөтөлбөрийн нэр: Экологи

Индекс: 052101 магистрын хөтөлбөр

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Нарангарвуу

Гишүүд: Ю.Дэлгэрмаа
Д.Хишигбаяр

Улаанбаатар хот
2022.12.10

Агуулга

Товчилсон үгийн тайлбар.....	3
I.Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт.....	4
II.Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	5
III.Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт.....	5
Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга	5
Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	10
Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил.....	14
Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн	20
Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт	23
Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем.....	26
Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	28
Ерөнхий зөвлөмж	32
IV. Ярилцлагад оролцогчдын нэрс	34
I. Багш нарын нэрс	34
II. Оюутны нэрс.....	34
III. Ажил олгогчдын нэрс	35
IV. Төгсөгчдийн нэрс.....	35
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	36

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АЭС	Агроэкологийн Сургууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
МДС	Магистр, Докторын Сургууль
МНСК	Монголын Номын Сангуудын Консорциум
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ХАА	Хөдөө Аж Ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
PDCA	Plan Do Check Act
ОХУ	Оросын Холбооны Улс
ArcGIS	Aeronautical Reconnaissance Coverage Geographic Information System

I.Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль (ХААИС) Магистр, докторын сургууль Mongolian University of Life Sciences	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Экологи Ecology	
Индекс	E05210101	
Шинжээчид	Ахлагч: Д.Нарангарвуу – Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх Ухааны сургуулийн Биологийн тэнхимийн Экологийн хөтөлбөрийн ахлагч доктор, дэд профессор Гишүүд: Ю.Дэлгэрмаа – Монгазар консалтинг компанийн захирал, доктор Д.Хишигбаяр - Монгол Улсын Боловсролын их сургуулийн Чанарын баталгаажуулалт, хяналт үнэлгээний албаны дарга	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа-Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.11.18	Шинжээчийн багтай гэрээ байгуулах
	2022.11.18	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хүлээн авах
	2022-11-25	Өөрийн үнэлгээний тайлантай танилцаж, судлан дүгнэлт хийх, тодруулах асуудал бүхий урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид илгээх
	2022-11-29	Шинжээчийн баг ХААИС-ийн Агроэкологийн сургуульд ажиллах
	2022-11-30	Шинжээчийн баг ХААИС-ийн Агроэкологийн сургуульд ажиллах
	2022-12-20	Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлт, тайланг илгээх.
Шалгуур шаардлага /журам/	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Уур амьсгалын өөрчлөлт, уул уурхай, хүн амын хэт төвлөрөлт, аж үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зохисгүй хэрэглээний улмаас байгаль орчны төлөв байдлын доройтол, орчны бохирдол, биологийн төрөл зүйлийн хомсдол зэрэг хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөг тодорхойлох, байгалийн төлөв байдлыг үнэлэх, судлах, нөөц, баялгийг зохистой ашиглах, хамгаалах олон улсын түвшинд ажиллах чадвар, мэдлэг бүхий ахисан түвшний боловсон хүчнийг олноор бэлтгэх шаардлага тавигдаж, ХААИС Экологи магистрын хөтөлбөрөөр 2003 оноос элсэлт авч эхэлжээ.

Экологи магистрын хөтөлбөр нь байгалийн нөөц баялаг, тэдгээрийн тархалт, элбэгшил, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг орчин үеийн шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, зохистой хэмжээ, даац, чадавхид нь тохируулан ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих, менежмент, бодлого хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх мэдлэг, чадвар бүхий боловсон хүчин бэлтгэхэд зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд: 1. Байгаль орчин, экологийн тулгамдсан асуудал, үйл явцад бодит дүгнэлт хийж, үнэлэх, асуудлыг тодорхойлох, 2. Судалгааны чиглэлээр уламжлалт болон орчин үеийн технологийн аргыг ашиглан туршилтын загвар боловсруулах, мэдээ цуглуулах, цуглуулсан мэдээнд статистик боловсруулалт хийх чадварыг эзэмшүүлэх, 3. Судалгааны үр дүнд дүгнэлт хийж аргачлал, заавар, зөвлөмж, стандарт, боловсруулах, төсөл, хөтөлбөр, байгаль орчны тайлан, өгүүлэл бичиж гүйцэтгэх чадварыг эзэмшүүлэх, 4. Суралцагчдын ажил мэргэжлийн онцлогт тохирсон мэдлэгийг олгох, олон улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий байгаль орчин, нийгэм, эдийн засаг, эрх зүйн уялдаа холбоог ханган ажиллах чадвар бүхий хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх. Экологи магистрын сургалтын төлөвлөгөө 2003 оноос хойш 2009, 2011, 2015, 2017, 2021 онуудад 5 удаа шинэчлэн сайжруулж, эдүгээ энэ хөтөлбөрөөр 91 магистр төгсжээ.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн баримт бичиг

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- БШУЯ-ны сайдын 2014 оны 9-р сарын 12-ны өдөр баталсан А/370 магистр, докторын сургалт эрхлэх журам, хөтөлбөр боловсруулах нийтлэг шаардлагын дагуу боловсруулсан.

- Агроэкологийн сургууль, ХААИС-ийн хөтөлбөрийн хороогоор хөтөлбөрийн хорооны журмын дагуу хэлэлцүүлсэн.
- ХААИС-ийн 2019 оны 4-р сарын 19-ний 1 тоот тушаалаар батлагдсан “ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө”-д тусгагдсан эрхэм зорилго, баримтлах бодлого, Агроэкологийн сургуулийн эрхэм зорилго, Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (IV зорилт), Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (XIII-XV зорилго), Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын VI зорилго, Шинэ сэргэлтийн бодлогын V зорилгод тус тус нийцүүлсэн боловсруулсан.
- Гадаадын их, дээд сургуулиуд (Шведийн Линкөпин их сургууль, ХБНГУ-ын Бремений их сургууль, Австри улсын Инсбракийн их сургууль, АНУ-ын Колорадгийн их сургууль) болон дотоодын их сургууль (МУИС)-ийн Экологи мэргэжлийн магистрын хөтөлбөртэй харьцуулалт хийж давуу талуудаа тодорхойлсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Экологи магистрын хөтөлбөр нь БШУЯ-ны хөтөлбөр төлөвлөлт, зохицуулалтын журмын дагуу хувь хүний болон мэргэжлийн чиглэлийг хөгжүүлэхээр нийгэм, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тогтоох боломжийг бүрдүүлэн ажилласан байна.
- Монгол улсын ХАА-н салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх, байгалийн нөөц баялаг, тэдгээрийн тархалт, элбэгшил, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг орчин үеийн шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, зохистой хэмжээ, даац, чадавхид нь тохируулан ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих, менежмент, бодлого хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх мэдлэг, чадвар бүхий боловсон хүчин бэлтгэхэд гадаадад докторын зэрэг хамгаалсан багш нар хичээл зааж, магистрын сургалтын үйл явц нь чөлөөт сонголттой.

Анхаарах асуудал:

- Хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлтийн судалгаа авч, анализ хийж, хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийн баримт бичгийг сайжруулдаг байх.
- Хөгжлийн бодлогуудад түшиглэж, хөтөлбөрөө сайжруулах давуу талыг олж авах.

Зөвлөмж:

- Хувийн хэвшлийн ажил олгогчдын төлөөллийн саналыг хөтөлбөрийн журам боловсруулахад оролцуулдаг байх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг хөтөлбөрийн зорилготой уялдуудан боловсруулсан.

- Энэ хөтөлбөрийн зорилгоос харахад суралцагч нь Экологийн шинжлэх ухааны онол, аргазүйн өндөр түвшиний мэдлэгтэй, бусад хавсрага шинжлэх ухааны судалгааны аргуудыг эзэмших, судалгааны ажлыг удирдагч багшийн удирдлага дор болон бие даан гүйцэтгэж, дотоод, гадаад хөдөлмөрийн зах зээлд ажиллах бүрэн боломжтой байна.
- Төгсөгчдийн мэргэжлийн мэдлэг чадварын түвшин, үнэлгээ сайн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Экологи магистрын хөтөлбөр нь Монгол улсын хөгжлийн бодлогууд, ХААИС, АЭС-ийн эрхэм зорилгод уялдуулан, олон улсын байгаль орчны чиглэлийн магистрын хөтөлбөрийн загвартай дүйцүүлэн мэргэжил, хувь хүн, нийгэм, бодлого, шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлтэй холбон төгсөгчийн загварыг боловсруулсан нь экологийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.
- Гадаад харилцаа сайтай, солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, дадлага хийх бүрэн боломжтой.

Анхаарах асуудал:

- Оролцогч талуудын судалгаа дутмаг байна.

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа авах
- Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах

1.3 Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшиний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол, дадлагын зохистой харьцаатай, харилцан уялдаатай, сонгон суралцах боломж ихтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн агуулгад хичээл заах улирал, кредитийн задаргаа, заах багш, холбогдох цахим хаяг, утас, ажлын өрөө, үндсэн болон нэмэлт сурах бичиг, ашиглах материал, хичээлийн өмнөх холбоо, хичээлийн тодорхойлолт, зорилго, оюутныг үнэлэх хэлбэр, хичээлд суусан/оролцсон байдлыг үнэлэх арга, хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт, хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар ба хичээлийн агуулгын хамаарал, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, боловсруулсан багш, шинэчилсэн огноо зэргийг багтаасан хичээлийн стандартын загвартай.
- Суралцагч сургалтын төлөвлөгөөний дагуу мэргэжлийн суурь 10 багц цаг, мэргэшүүлэх 12 багц цагийн хичээлийг сонгон суралцана. Судалгааны семинар 4, магистрын ажил 7 нийт 33 багц цагийг 25%-ийг танхимд, 75%-ийг бие даан судлан төгсөж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Экологи магистрын хөтөлбөр нь ахисан түвшний сургалтын журмын дагуу мэргэжлийн суурь хичээл, мэргэшүүлэх хичээлээр онол, дадлагын мэдлэг олж авах үйлээр дамжуулан сурах зэргээр хөтөлбөрт суурилсан, идэвхтэй арга хэлбэрийг зохистойгоор хослуулсан байна. Суралцах үйл ажиллагааг суралцагч төвтэй боловсруулж, суралцагчийн судалгааны ажлыг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Магистрант хөтөлбөрийн агуулгын 75%-ийг бие даан суралцахад чанартай мэдлэг олж авах эсэх нь эргэлзээтэй байна.

Зөвлөмж:

- Бие даан суралцах цагийг хянах, магистрант чанартай мэдлэг олж авч буйг батлах судалгаа хийх.
- Төгсөгчдийн хүсэлтээр мэргэжлийн англи хэл, чөлөөт сонголтын хичээлийн багц цагийг нэмж оруулах.

1.4 Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

Экологи хөтөлбөрт мэргэжлийн суурь хичээлийн 10 багц цагт Судлаачийн ёс зүй, судалгааны ажлын төлөвлөлт, бүтээл бичих арга, Байгаль шинжлэлийн судалгааны арга зүй зэрэг хичээлүүдийг заавал судалдаг. Мэргэшлүүлэх 22 хичээлээс суралцагч нь 12 багц цагийн хичээлийг сонгон суралцахаар төлөвлөгдсөн. Суралцагч нь өөрийн судалгааны нарийн чиглэлтэй уялдуулан сонголтоо хийж, суралцах боломжтой байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилго нь хүрэх үр дүнгээр тодорхойлогдох бөгөөд хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон хичээл бүрийн суралцахуйн үр дүнгээр матриц хийж, сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага хоорондын уялдааг нарийн тодорхойлсон.
- Мэргэжлийн ур чадвар олгох хичээлүүд нь харьцангуй шинэлэг лабораторийн орчинд, туршилт судалгаа явуулах замаар дадлагад суурилдаг бол зарим хичээлүүд холимог хэлбэрээр сургалтын аргуудыг хослуулан хэрэглэдэг байна.
- Магистрын зэрэг олгох хөтөлбөр нь илүү хэрэглээ рүү хандсан салбар шинжлэх ухааны үндсэн зарчим, судалгааны нарийн арга зүй эзэмшүүлэх, шинжлэх ухаанд хувь нэмэр оруулахуйц үр дүн гаргаж, ирээдүйд инновац болох магадлал бүхий суралцахуйн үр дүнд хүргэхэд ахисан түвшний суралцагчийг чиглүүлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Экологи магистрын хөтөлбөр нь БШУЯ-ны 2014 оны 9-р сарын 12-ны өдөр баталсан А/370 магистр, докторын сургалт эрхлэх журмын дагуу мэргэжлийн

суурь хичээлүүдээр туршилт судалгааны ерөнхий арга зүй, судалгааны үр дүнг нийтэд мэдээлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажилд ёс зүйтэй хандах талаар суурь мэдлэгүүдийг олгох зорилготой суурь хичээлүүдийг үзэж хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хангасан төдийгүй сонгон судлах хангалттай хичээл боловсруулсан байна.

- Судлаачийн ёс зүй, судалгааны арга зүй зэрэг ажлын байранд гарахад хамгийн хэрэгтэй хичээлүүд түлхүү орсон байна.
- Судалгааны аргазүйг талбайн болон хээрийн дадлага, төсөлт ажлуудаар дамжуулан чадвар, дадал болгон эзэмшүүлдэг.

Анхаарах асуудал:

- Ямар үндэслэлээр эдгээр сонгон суралцах хичээлийг сонгосон талаар мэдээлэл дутмаг. Тухайлбал, Бүлгэмдлийн экологи хичээл сонгон судлах хичээлд тавигдсан байна.
- Хөтөлбөрөө шинэ нээлт, арга зүй, шинэ мэдээ баримтаар тогтмол баяжуулах, ашиглах сурах бичгээ сайжруулах
- Бусад хөтөлбөрөөс сонгох хичээлийн багц цагийг тавьж өгөх
- Зарим бакалавр, магистрын хичээлүүдийн нэр өөр боловч хичээлийн агуулга ижил байгааг анхаарах, давхардлыг багасгах

Зөвлөмж:

- Байгаль орчны эрх зүй, Байгаль орчны эдийн засаг, Байгаль орчны үнэлгээ аудит хичээлүүд бакалаврын түвшинд байгаа учраас агуулгыг харьцуулан давхцуулахгүй байх, ялгааг гаргах, ахисан түвшинд хүргэх
- Мөн эдгээр хичээлүүдийн сурах бичгүүд яг ижил байгааг шалгах, бусад боломжит эх сурвалжийг ашиглах, ашиглах сурах бичиг сайжруулах

1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

- Экологийн хөтөлбөр нь 2003 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд Монгол улсын БСШУ-ны сайдын 2014 оны А/370 тоот тушаалын дагуу E052101 индекстэй байна.
- 2009, 2011, 2015, 2017, 2021 онуудад сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулсан.
- Хөтөлбөрийн чанарын хяналт, баталгаажуулалтыг хөндлөнгийн болон дотоод хяналт хариуцсан гишүүд нь А/370-ын 2.11.1-т заасан үнэлгээний үзүүлэлтээр дүгнэн шинжлээд, хөтөлбөрийн хороонд тайлагнах зарчмаар явагдана. Эдгээр гишүүдийн тайлангаас гарсан санал шүүмжийн дагуу хөтөлбөрийн хороо нь сургалтын үйл ажиллагааг сайжруулах, хөгжүүлэх бодлогыг баримтлан ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2021 оноос Экологийн хөтөлбөр стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.
- Хичээлийн хөтөлбөрүүдийг суралцагчдын мэдлэг, ур чадвар, хандлагад тулгуурлан, төгсөгчийн загвар боловсруулан хэрэгжүүлж байна.

- Олон улсын хэмжээнд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг 4 сургуультай харьцуулахад хөтөлбөрийн хичээлүүд 50 орчим хувийн төсөөтэй байна. Сонгон судлах хичээл олон болохоор судалгааны чиглэл дагуу хичээл үзэх боломжтой.

Анхаарах асуудал:

- Сонгон судлах хичээлийг боловсон хүчний нөөцдөө тохируулах биш, мэргэжлийн онцлогтойгоо уялдуулах

Зөвлөмж:

- Бакалаврын хөтөлбөрт буй хичээлүүдийн давхардлыг багасгах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

2.1 Элсэлт

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOFEL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

Илрэл нотолгоо:

- “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ын 1.3-т заасны дагуу Магистр, докторын сургуультай. Захирал, сургалтын албаны дарга, 2 мэргэжилтэн суралцагчдад үйлчилдэг.
- Экологи хөтөлбөрөөр магистрын хөтөлбөрт суралцахыг хүсэгчдийн шалгаруулалт ХААИС-ийн магистрын элсэлтийн журмаар бүрэн зохицуулагдсан бөгөөд шалгалтыг Магистр, докторын сургууль шударга, ил тод зохион байгуулдаг.
- Элсэлт авах тухай зар хэвлэл мэдээлэл, ХААИС-ийн албан ёсны вэб сайтаар 2-3 долоо хоногийн өмнө тавигддаг бөгөөд нээлттэй.
- ХААИС-ийн магистрын элсэлтийн журамд гадаадын суралцагчийн боломжийг тусгаж өгсөн. Зохих гэрээ хэлэлцээрийн дагуу элсүүлнэ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Экологийн магистрын хөтөлбөрт элсэх явц хялбар, нээлттэй, шударга бөгөөд голч оноо өндөр суралцагчид шалгалтгүй элсэх, сургалтын төлбөрийн хөнгөлөлт авах боломжтой.
- Бакалаврт эзэмшсэнээс өөр мэргэжлээр магистрын хөтөлбөрт хамрагдах бол сургалтын залгамж чанарыг хангахад шаардагдах хичээлийг урьдчилан судлах боломжтой. Сургууль хооронд шилжих бол кредитийн зөрүү төлбөр авдаггүй бөгөөд суралцахуйн ачаалал харьцангуй жигд.

- Зах зээлийн эрэлтээ дагаад элсэгчид нэмэгдэж байгаа.

Анхаарах асуудал:

- Чанаргүй олон суралцагчийг хэрхэн идэвхжүүлэх
- Магистрын судалгааг санхүүжүүлдэг эсэх
- Магистрын хичээлийн үнэлэмж, судалгааны ажлыг санхүүжүүлэх зэрэг цалин хөлсний нэмэгдэл олгох талаар боловсон хүчний бодлого, хууль, журамд тусгах

Зөвлөмж:

- Магистрын судалгааны ажлыг санхүүжүүлэх гарц хайх
- Хөтөлбөрийн сурталчилгааг төгсөгчдөөр дамжуулан сурталчлах

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрт жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын сургалтын хөтөлбөрт суралцах хугацаа 1.5-2 жил, ба элсэлт, төгсөлт “намар”, “хавар” гэсэн хоёр улиралтай
- Мэргэжлийн суурь хичээл 10 кр, мэргэшүүлэх хичээл 12 кр, судалгааны семинар 4 кр, магистрын судалгааны ажил 7 кр нийт 33 кр судалдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын сургалтын хөтөлбөрийг сургуулийн зүгээс академик эрх чөлөөгөөр хангаж өгсөн бөгөөд танхимаар хичээллэх цаг бага тул судалгаа хийх хангалттай цагтай бөгөөд суралцагч ачааллаа тохируулан хичээл сонгох эрхтэй тул зохицуулалт хийж болно.
- Мэргэжлийн хичээлээ үзсний дараа намар 3, хавар 3 сар хичээллэх тул ачаалал харьцангуй жигд.
- Хөтөлбөрийн сургалтад онлайн нээлттэй, зайн сургалтын арга хэлбэрийг ашигладаг.
- Суралцагч хичээлийн багц цагаа гүйцэтгэж, биелэлтээ хангасан бол магистрын судалгааны ажлаа ямар ч цагт хамгаалах боломжтой.

Анхаарах асуудал:

- Төрийн зээлээр суралцагчид судлах хичээлийн багц цаг хязгаарлагддаг учраас магистрантуудад ачаалал харилцан адилгүй байх талтай.
- Магистрантуудын нийгэмд оролцох идэвхийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Захирлын 2014 онд батлагдсан “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ын 2.8-д магистрын сургалтад багшлах бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг хангасан байна.
- Магистрын хөтөлбөрт хичээл заадаг багш нар 100% докторын (Ph.D.) зэрэгтэй, 75-аас дээш хувь нь профессор, дэд профессорын зэрэглэлтэй, олон улсын, үндэсний төсөл хөтөлбөрийн удирдагч, гүйцэтгэгчээр ажилладаг, өндөр хөгжилтэй дэлхийн улс орнуудад суралцаж төгссөн, мөн гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж сургалтад хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн судалгааны болон суралцахуйн арга барилыг хөгжүүлэхийн тулд багш нараа чадавхжуулах алхам хийж, гадаад, дотоодын сурган заах арга зүйн олон сургалтад хамруулж идэвхтэй сургалтын аргыг хөтөлбөртөө хэрэглэдэг. Сүүлийн жилүүдэд дотоодын сургалтад 7 багш, гадаадын сургалтад 4 багш хамрагджээ.
- Багш нар судалгааны ажлаа семинараар танилцуулж судлаачийн арга барилыг хөгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- Сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, багаж, эм урвалж, сурах бичгээр хангах
- Сургалтад суусан үр дүнгээ хэрэгжүүлэх

Зөвлөмж:

- Мэргэжлийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх

2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна

Илрэл нотолгоо:

- Удирдагч багшийг сонгох, томилох нь тухайн суралцагчийн өөрийн сонголтын үндсэн дээр явагддаг.
- Удирдагч багш, оюутан харилцан зөвшилцөж сэдвээ тогтон ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулан Магистр, докторын сургуулийн захирал баталгаажуулдаг.
- Суралцагчид мэргэжлийн суурь хичээлээ үзэж дууссаны дараа судалгааны ажлын арга зүйг удирдагч багшийн хяналт, заавар зөвөлгөөний дагуу боловсруулж харьяа мэргэжлийн профессорын баг, тэнхимийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн зүгээс хичээл сонголт, судалгааны сэдэв сонгох, удирдагч сонгоход чөлөөтэй ханддаг.

- Удирдагч гадаад, дотоодын төсөлд бүрэн хамруулах боломжтой.
- Удирдагч нь судалгааны ажлын сэдэв, арга зүй, судалгааны семинар зохион байгуулах, хэлэлцүүлэг хийх, хамгаалтад орох зөвшөөрөл олгодог.
- Судлаач нь эрдэм шинжилгээний хуралд нэгээс доошгүй илтгэл хэлэлцүүлж, зөвшөөрөгдсөн сэтгүүлд нэг өгүүлэл хэвлүүлдэг.
- Судалгааны ажил нь тухайн сэдвээр онол, арга зүй, үр дүн, дүгнэлт, зөвлөмж бүхий нэг сэдэвт бүтээл байна.
- Магистрант оюутнуудад зөвлөн туслах үйлчилгээ сайн, судалгааны семинарыг тогтмол зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Нэг багшид ногдох ачаалал, магистрантыг удирдах санхүүжилт хүртээмжтэй эсэх
- Залуу багш нарт магистрын ажил удирдах боломж олгох
- Магистрантын судалгааны зардлыг удирдагч багш өөрсдийн судалгааны төслөөс гаргадаг.
- Зарим тохиолдолд судалгааны зардлаа оюутан өөрсдөө гаргадаг.

Зөвлөмж:

- Магистрантын судалгааг санхүүжүүлэх гарц хайх
- Судалгааны ажлын үр дүнг олон улсын сэтгүүлд хэвлүүлэх боломжоор хангах

2.5 Бүтээлч ажил

Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн хэмжээнд “Магистр, докторантын эрдэм шинжилгээний бага хурал зохиогддог.
- “Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд тэтгэлэг олгох журам”-тай.
- Олон улсын болон улсын хэмжээний төсөл хөтөлбөрүүдэд магистрант оюутнууд хамрагддаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрантууд гадаадын төсөл хөтөлбөрт орж судалгаа хийх, семинар хэлэлцүүлдэг.
- Сургуулийн хэмжээнд магистр, докторын эрдэм шинжилгээний хуралд магистрантууд нь тогтмол амжилттай оролцдог.

Анхаарах асуудал:

- Магистрантын бүтээлч ажлыг дэмжих, урамшуулах нь дутмаг
- Судалгаанд орчин үеийн судалгааны арга, тоног төхөөрөмж, урвалж бодис хэрэглэх

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулдаг.

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУ-ны сайдын 2014 оны А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, мөн сайдын 2007 оны 187 тоот тушаалаар батлагдсан “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”- ийг тус тус баримтлан ажилладаг.
- Магистрантудын мэдлэг, чадварын үнэлгээ нь ХААИС-ийн Захирлын 2017 оны А/187 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "ХААИС-ийн ахисан түвшинд суралцагчдыг үнэлэх үнэлгээний журам"-ыг баримталдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (хичээлээр эзэмших мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хувь хүний ур чадвар, хандлага)-г үнэлэх тогтолцоо бүрдэж, хэрэгжиж байна.
- Суралцагчдийн үнэлгээг явцын, улирлын, ур чадварын, бусад гэсэн үе шатаар 100 онооны системээр үнэлж хэвшсэн байна. Оюутны мэдлэг, чадварыг дүгнэхдээ бие даан суралцах үйл ажиллагааг хөгжүүлэх, оюутны сурах, багшийн сургах үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх зарчмыг удирдлага болгодог байна.
- Тэнхим бүр магистрантын сурлагын амжилтын судалгааг улирал бүр хийдэг. Төгсөгчдийн голч дүнгийн судалгаанаас үзэхэд 3.2-3.9 байна.
- Багш нарын заах арга зүй, ур чадварын талаар суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгаа өндөр үнэлгээтэй байна.
- Багш хичээлийн улирлын дүнг мэдээллийн системд заасан хугацаанд оруулах үүрэгтэй. МДС-ийн мэргэжилтэн хяналт тавьж ажиллана. Суралцагч явцын, улирлын дүнтэй цаг тухайд нь танилцаж, дүгнэлт хийх бөгөөд гомдол маргаан гарсан тохиолдолд багшид мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд сургалтын албанд өргөдөл гаргаж шийдвэрлүүлнэ.

Анхаарах асуудал:

- Сүүлийн үеийн дэвшилтэт технологид шаардлагатай тоног төхөөрөмж, эм урвалж, багаж худалдан авах зардал хомс байна.
- Суралцагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, анги танхим спортын заал, бие даан суралцах анги танхимын хүрэлцээ, хүртээмж тааруу байна.

Зөвлөмж:

- Сургалтанд шаардлагатай тоног төхөөрөмж, эм урвалж, багаж худалдан авах боломжийг хайх.

- Суралцагчдыг хөгжүүлэх бие даан суралцах анги танхимын тохижуулах.

3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна

Магистрантын бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 2014 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/370 тушаал (Хавсралт 5.3)-аар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ыг үндэслэн мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай журмын дагуу хөтөлбөрөө боловсруулж, суралцагчийн эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлж байна.
- Мөн ХААИС-ийн захирлын 2014 онд батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам” 2.7.2-д заасны дагуу бакалаврын сургалтын 15-30 кредитийг үзсэн байхаар дүйцүүлэлтийг хийдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Өөр сургууль, хөтөлбөрөөр суралцсан суралцагчдын суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрсөн эрх зүйн бичиг баримттай, багц цагийг дүйцүүлэх тогтолцоо бүрдсэн.
- Энэхүү мэргэжил нь Монгол улсад эрэлттэй, хувийн болон төрийн салбар ажиллах, ажлын байр бий болгох бололцоотой, хамгийн гол нь төрийн бодлого, хууль эрх зүйн түвшинд дэмжигдэж баталгаажсан.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн албан бичиг хөтлөлт, эрх зүй, гадаад хэлний мэдлэг зарим тохиолдолд ажлын байранд тавигдах шаардлагаас доогуур байгаа юм байна.
- Дадлагажих хугацаа бага байна.

Зөвлөмж:

- Ажил олгогч нарын нийтлэг шаардлагын дагуу албан бичиг хөтлөлт, эрх зүй, гадаад хэлний мэдлэг ажлын байранд тавигдах шаардлагад нийцэх байдлыг сайжруулах,
- Дадлагажих хугацааг хангалттай болгох.

3.3 Магистрантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Магистрантыг амжилттай суралцах, судалгааны арга зүй эзэмших, хөгжихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчдад зөвлөн туслах үйлчилгээ болон гадаад, дотоодын их дээд сургуулиас шилжин суралцах, багц цагийн дүйцүүлэлтийг ХААИС-д магистрант суралцагчаар шилжин суралцуулахад Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам” зэргээр системтэйгээр зохицуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийг 3.2-оос дээш голч дүнтэй төгссөн тохиолдолд магистрантурт шалгалтгүй элсүүлж, сургалтын төлбөрийг 15% хөнгөлдөг.
- Суралцагч хичээлийг өөрөө сонгож, хичээлийн ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж, хичээлийн хуваарийг зохицуулдаг тул оюутан өөрийгөө хөгжүүлэх, үндсэн ажлаа хийх, цагаар ажиллах зэргийг урьдчилан төлөвлөж болно.
- Сургуулийн хамт олон оюутан судлаачдаас нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа зохион байгуулахад сургуулийн зүгээс тогтмол дэмжлэг үзүүлдэг.
- Зайны сургалтыг дэмжих, хөгжүүлэх ажил явагдаж байгаа.
- Магистрантыг бие даан суралцах академик эрх чөлөөтэй.

Анхаарах асуудал:

- Суралцагчдад зориулсан хувь хүний хөгжлийн болон нийгмийн эрүүл мэнд, гэмт хэргийн сургалтанд оролцох идэвхи бага байна.
- Тусгайлан ахисан түвшний суралцагчдад зориулсан олон нийтийн үйлчилгээ дутмаг.
- Магистрант докторантын оюутны холбоо байгуулагдаагүйгээс нийгмийн хамгаалал, соёл, урлаг, спортын асуудлын үйл ажиллагаа дутмаг байдаг.

Зөвлөмж:

- Магистрантыг амжилттай суралцахад дэмжих орчин үеийн судалгааны лаборатори, орчин нөхцөлийг бүрдүүлэх.
- Магистрант докторантын оюутны холбоо байгуулах.

3.4 Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан болон бүрэлдэхүүний сургуулийн санхүүгийн тайлангаас үзэхэд судалгааны санхүүжилт олгодог бөгөөд суралцагчдын төлбөрөөс хөнгөлөлт үзүүлдэг байна. Эдгээр нь “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-аар зохицуулдаг байна.
- Мөн магистр, докторантын эрдэм шинжилгээний шилдэг илтгэл шалгаруулж, судалгааны тэтгэлэг олгож, урамшуулдаг байна. Мөн жилийн нийт төлбөрийн 0.05 хүртэл хувийг төсөвт тусган зарцуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрант, докторантууд судалгааны ажлын үр дүнгээр эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, шалгарсан тохиолдолд урамшуулал авдаг.

Анхаарах асуудал:

- Судалгааны санхүүжилт олон талт эх үүсвэрээс жилээс жилд нэмэгдэж байгаа хэдий ч эдгээр санхүүжилтээс магистрын судалгааны ажилд зарцуулах хэмжээ тодорхойгүй байна.
- Судалгааны санхүүжилтийг тайлагналыг оновчгүй байна.

Зөвлөмж:

- Сургалтын төлбөрөөс үзүүлж буй хөнгөлөлтийг санхүүгийн тайлангийн хөнгөлөлт хэсэгт харуулах, судалгааны санхүүжилтийг тайлагналыг оновчтой болгож, магистрын судалгааны ажилд зарцуулах хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

3.5 Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Жил бүр шилдэг суралцагчид БШУ-ны сайдын 2010 оны “Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, грант олгох журам”, ХААИС-ийн 2016 оны “Хөдөө аж ахуйн салбарын залуу судлаачдад Инновацийн грант олгох журам”, ХААИС-ийн захирлын 2016 оны “Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээл олгох журам”-ийн шаардлагын дагуу шалгаруулалтад орж, тэтгэлэгт хамрагддаг.
- ХААИС нь бакалаврын 3.2-гоос дээш голч оноотой төгсөгчдөөс шалгалтгүйгээр магистрын хөтөлбөрт элсэн орох урилга өгч 15 хувийн хөнгөлөлт үзүүлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Оюутны тэтгэлэг, урамшууллын тогтолцоог дээрх журмуудаар хангаж өгсөн.
- Магистрантууд тодорхой болзол шалгуурыг хангаснаар төрөл бүрийн хөнгөлөлт, тэтгэлэг хамрагдах боломжтой харагдаж байна. Тухайлбал, магистрант, докторантыг ХААИС-ийн гадаад оюутан солилцооны хөтөлбөр, төсөл, судалгаа, экспедицийн ажилд нэн тэргүүнд оролцуулах бодлого баримталдаг.
- Мөн гадаад, дотоодын төсөл, гэрээт ажлуудад магистрантууд туслах судлаачаар оролцож цалинжихаас гадна судалгааны ажлын шаардлагатай урвалж, лабораторийн техник хэрэгслийн зардлыг гаргадаг давуу талтай байна.

Анхаарах асуудал:

- Магистрантууд багш нарын төсөл, хөтөлбөрт хамрагдахгүй л бол судалгаа хийх зардал байхгүй байна.

Зөвлөмж:

- Илтгэл, урамшууллаас гадна нийт магистрантуудын судалгаа, туршилт хийх урвалж, багажаар жигд хангах хэрэгтэй.

3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн захирлын 2016 оны А/140 тушаал, ХААИС-ийн Захирлын 2016 оны А/87 тоот тушаал, профессорын багийн ажиллах журмын хүрээнд магистрантурт хичээл заах багш нар хөдөлмөрийн гэрээ байгуулж, судалгааны багууд ажиллаж байна.
- Гадаад, дотоодын их сургуулиудтай хамтарсан гэрээ байгуулж, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, судалгааны ажил гүйцэтгэхээс гадна магистрантуудыг хамруулан судалгааны ажил хийлгэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС нь 2014 оноос судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд судалгааны багуудыг байгуулж, гадаад, дотоодын урт, богино хугацааны төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сүүлийн таван жилд дөрвөн багшийн удирдлага дор 10 магистрант судалгааны ажил гүйцэтгэж, олон улсын хуралд итгэл хэлэлцүүлж, магистрын зэргээ амжилттай хамгаалжээ.
- Судалгааны семинарыг тогтмол зохион байгуулдаг. Магистрантуудын судалгааны ажлыг хэлэлцүүлэх семинар 2019 оноос 24 удаа танхим болон онлайнаар, зочин профессорын семинар 12 удаа явагджээ.
- Сүүлийн 5 жилд ХААИС-ийн стратеги төлөвлөлтийн дагуу суралцагч төвтэй судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд гадаадын их, дээд сургууль, судалгааны байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан судалгааны болон солилцооны хамтарсан хөтөлбөрүүд боловсруулан ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Залуу багш нарт судалгааны тэтгэлэг бага олдож байгаа учраас магистрын судалгаа удирдах, лабораторийн тоног төхөөрөмж урвалж, авах, хангамж харилцан адилгүй байна.

Зөвлөмж:

- Судалгааны санхүүжилтийг нэмэгдүүлж, хангамжийг сайжруулах, хамрагдах магистрантын тоог нэмэх.
- Залуу багш нартайгаа хамтран гадаад дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгааг нь дэмжих.

3.7 Магистрын ажил хамгаалалт

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- БШУЯ-ны сайдын 2014 оны 9 дүгээр сарын 12 -ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, ХААИС-ийн Захирлын 2014 онд “Магистр, докторын сургалтын журам”-ийн дагуу магистрын судалгааны ажил хамгаалалт тэнхимийн семинарт хэлэлцүүлсний дараа мэргэжлийн комисст урьдчилан болон жинхэнэ хамгаалалт хийж, дэс дараатайгаар зохион байгуулагддаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн хувьд магистрын ажилд тавих шаардлага, магистрын ажлын хамгаалалтыг зохион байгуулах дэг нь багш суралцагчдад тодорхой, дүрэм журмаар баталгаажсан ба МДС нь тус хөтөлбөрөөр элсэх өргөдөл гаргаснаас төгсөлтийн баримт бичгийг гардан авах үйл ажиллагаа хүртэлх сургалтын бүхий л үйл явцыг хариуцдаг.
- Экологийн хөтөлбөрийн магистрын ажлыг хамгаалах салбар зөвлөл нь БШУЯ-ы сайдын баталсан дүрмийн дагуу тухайн салбарын нэр хүндтэй эрдэмтдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан, бүрэлдэхүүн нь тодорхой хугацаанд тогтмол шинэчлэгдэж байна.
- Магистрын судалгааны ажил удирдагч нь докторын зэрэгтэй, их, дээд сургууль эсхүл эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, энэхүү журмын 3.1.5-д заасан эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлтэй, идэвхтэй судлаачид байна.
- Магистр, докторын судалгааны ажлын удирдагч нь өөрийн тэнхим, профессорын баг, лабораторийн түвшинд болон бусад нэгжтэй хамтарсан байдлаар магистрант, докторантын туршилт, судалгааны ажлын арга зүй, үр дүн бие даалтын ажлын явц зэргийг хуваарийн дагуу тогтмол хэлэлцүүлж, судалгааны семинар зохион байгуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Тус хөтөлбөрөөр элссэн магистрантын тоо харьцангуй олон боловч, судалгааны ажлаа дуусгаагүй магистрант цөөнгүй байна.
- Зарим багш нар олон магистрант удирдаж байна.

Зөвлөмж:

- Элссэн магистрантуудыг төгсгөх, судалгааны чиглэлүүдэд жигд зөвлөх, багшийн ачааллыг жигд болгох.

3.8 Төгсөлтийн баримт бичиг

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Илрэл нотолгоо:

- БШУЯ-ны сайдын 1997 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 59 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын төгсөлтийн шалгалтын үлгэрчилсэн журам”, 2006 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 480 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын диплом олгох журам”, ХААИС-ийн Захирлын 2014 онд “Магистр, докторын сургалт журам”-д тусгагдсан зааврын дагуу төгсөлтийг баримт бичиг бүрддэг.

- Магистрын судалгааны бүтээл МДС-ийн номын сан болон ХААИС-ийн Байгалийн ухааны салбарын номын санд бүртгэлжин хадгалагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 тоот тушаал “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэн гаргасан МДС-ийн дотоод журмын дагуу төгсөлтийн материалыг бүрдүүлдэг.
- Диплом олгох үйл ажиллагааг БШУЯ-ны сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу зохицуулдаг.
- Диплом гардуулах ёслолыг жилд 2 удаа (12 сард, 6 сард) зохион байгуулж байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

4.1 Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Экологи хөтөлбөрт хичээл заах багшийн сонгон шалгаруулалт, шаардлага нь ХААИС-ийн захирлын 2017 оны 04 сарын 20-ны өдрийн А/86 тоот тушаалын дагуу гарсан ХААИС-ийн профессор багш ажиллуулах журмаар зохицуулагддаг.
- “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-д нийцүүлэн багшийг сонгож, хүний нөөцөө бүрдүүлэн ажилладаг.
- Хөтөлбөрт орох хичээлүүд болон багшлах бүрэлдэхүүнийг сонгохдоо хөтөлбөрийн хороогоор хэлэлцэх ба хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг Эрдмийн зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн батлана.
- “Магистр, докторын судалгааны ажлын удирдагч нь өөрийн тэнхим, профессорын баг, лабораторийн төвшинд болон бусад нэгжтэй хамтарсан байдлаар магистрант, докторантын туршилт, судалгааны ажлын арга зүй, үр дүн бие даалтын ажлын явц зэргийг хуваарийн дагуу тогтмол хэлэлцүүлж, судалгааны семинар зохион байгуулдаг байна” гэсний дагуу багшийн сонголтыг хийж, магистрын хөтөлбөрт хичээл заах багш нарын бүртгэлд 13-15 багш бүртгэлтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Экологийн магистрын хөтөлбөрийн хувьд багшлах нөөц хангалттай, 100% доктор зэрэгтэй багштай, хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын ажилласан жил дунджаар 22,1 байгаа нь мэдлэг, туршлага сайн, сургалтын онол арга зүйн болон мэргэжлийн бэлтгэлийн нөөц сайн байгааг харуулж байна.

Анхаарах асуудал:

- Судалгааны зарим чиглэлүүдэд шавь сургалт байхгүй.

Зөвлөмж:

- Судалгааны зарим чиглэлээр шинэ боловсон хүчнийг бэлтгэж эхлэх.

4.2 Багшлахуйн үнэлгээ

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийдэг.
- ХААИС-ийн багш нарын сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн, үйлчилгээний (зөвлөх үйлчилгээ) чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог.
- Жил бүр их сургууль, бүрэлдэхүүний сургууль, тэнхимийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын биелэлтийг тэнхимийн хамт олондоо өөрийн үнэлгээний тайлангаа илтгэж, баримт материалаа баталгаажуулан тооцдог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш хөгжил хөтөлбөр нь сургуулийн хөгжлийн бодлоготой шууд уялддаг тул захиргааны болон санхүүжилтийн дэмжлэг авах магадлал өндөр байдаг.
- Багш, тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд өөрийн төлөвлөгөө, тайланг боловсруулж хэвшсэн байна.
- Багш бүр өөрийн үнэлгээг хийж тайлагнан тэнхим нэгжээр хэлэлцүүлэн хөндлөнгийн үнэлгээ, зөвлөмж хүргүүлдэг байна.
- Хөтөлбөрт мэргэжлийн хичээл ордог багш бүрийн сургалтад оролцогчоос сэтгэл ханамжийн 5 багц чиглэлээр судалгаа авч багшийн мэргэжлийн бэлтгэл, хөгжлийн үнэлгээ гэх мэт олон хэлбэрээр багшийн ажлыг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлж эхэлсэн нь сайшаалтай байна.
- Аттестатчлалын үр дүнгээр тухайн хөтөлбөрт хичээл заадаг 1 багш дэд профессорын албан тушаалд ахисан бөгөөд зэрэглэл буурсан багш байхгүй.
- Багшийн сургалтын ур чадвар, заах арга, ёс зүйн талаар сэтгэл ханамжийн судалгааг 2017 оноос 5 хэмжүүрээр авч эхэлсэн бөгөөд судалгаанд хамрагдсан судалгааны үр дүнгээс харахад сэтгэл ханамжийн үнэлгээ 3.6-4.8 хооронд буюу дунджаар 4.5 гэсэн үнэлгээтэй дүгнэсэн байна.

Анхаарах асуудал:

- Багш нар судалгааны арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд харилцан адилгүй хамрагдаж байна.
- Багш нар албан тушаалын зэрэглэл ахих нь харьцангуй бага.

Зөвлөмж:

- Багш нар мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд сургуулийн зүгээс үе шаттай арга хэмжээ авах,
- Багш нарыг албан тушаалын зэрэглэлээ ахиулахад анхаарах хэрэгтэй.

4.3 Багшийн хөгжил

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инноваци нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын хэмжээнд 2019 оны 1-р сарын 01-нээс мөрдсөн “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль, 2016 оны 6-р сарын 27-ний өдрийн хууль, ХААИС-ийн ректорын 2002 оны 11-р сарын 20-ны өдрийн 156 тоот тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөрийн бодлогын баримт бичгийг ХААИС-ийн тэнхимийн эрхлэгчдийн 2017 оны 02-р сарын 23-ний өдрийн тушаалаар сайшааж, захиргааны зөвлөлийн 2017 оны 03-р сарын 23-ний өдрийн хурлаар батлагдсан баримт бичгийг ХААИС-ийн багшийн хөгжилд мөрддөг болсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Судалгааны их сургууль байх эрхэм зорилгыг ХААИС-ийн хөгжлийн бодлогодоо тусгаж, “Багшийн хөгжил хөтөлбөр” боловсруулсан нь сайн жишиг байна.
- Багш нар хувь хүний хөгжлийн, судалгааны чадамж хөгжүүлэх, сургахуйн чадамж хөгжүүлэх чиглэлээр сургалтад хамрагдаж, судалгаагаа хөгжүүлэхэд анхаарч гадаадын төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байна. Дотоодын сургалтанд 55.5 хувь нь мэргэжлийн, 26.7 хувь нь сурган заах арга зүй, 10.9 хувь нь судалгааны чадавх, 6.9 хувь нь мэдээллийн технологийн чиглэлээр тус тус мэргэжил дээшлүүлжээ.
- Бүх багш нар докторын зэргээ хамгаалсан бөгөөд цол, зэргээ ахиулах зэргээр хөгжиж сүүлийн 3 жилд дэд профессор багш нэгээр нэмэгдсэн.

Анхаарах асуудал:

- Багшийг хөгжүүлэх хөтөлбөрт тусгасан зорилтууд бодитой хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих

Зөвлөмж:

- Багш нарын судалгааны чиглэлтэй холбогдуулан инновац, гарааны компани байгуулж, санхүүжилт олох боломжийг хайх

4.4 Судалгаа ба хөгжил

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Профессорын багууд болон багш нар олон улсын болон үндэсний хэмжээний төсөл авч, судалгааны ажлаа хийж, оюутнуудыг дагалдуулан сургадаг.
- ХБНГУ, Австри, Япон, БНЧУ зэрэг гадаадын их сургуулиуд, ШУТсан, бусад олон байгууллагуудтай хамтран олон улсын болон дотоодын захиалгат болон гэрээт төслийг хамтран хэрэгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар өөрийн судалгааны багийг бүрдүүлж, гадаадын төсөл, хөтөлбөр тасралтгүй хэрэгжүүлж, магистр, докторын оюутнуудыг байнга хамруулдаг байна. Сүүлийн жилүүдэд ХБНГУ, Австри, Япон, Чер зэрэг гадаадын их сургуулиудтай, ШУТсан, бусад олон байгууллагуудтай хамтран олон улсын болон дотоодын захиалгат болон гэрээт төслийг хэрэгжүүлж байна.
- Багш нар бүтээлээ хэвлүүлсэн байдлыг үндэслэн багшийг оны шилдэг багшийн урамшууллаар шагнах, ХААИС-ийн болон АЭС-ийн шилдэг багшийг шалгаруулах журмын дагуу шалгаруулах, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн ба ишлэл татагдсан байдлыг харгалзан урамшуулал олгох зэргээр дэмждэг.
- Судалгааны үр дүнгээр хөтөлбөрийн багш нарын импакт фактор бүхий олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлдэг. Багш нараас сүүлийн 5 жилд олон улсын IF-тэй сэтгүүлд (1.9-5.79 IF) 14 өгүүлэл, мэргэжлийн гадаад хэлээр хэвлэгддэг ба гадаадад хянагддаг сэтгүүлд 47, улсын хэмжээнд 117 өгүүлэл хэвлүүлсэн байна.
- ХААИС-ийн шилдэг залуу багш, шилдэг судлаач багш, шилдэг сурган хүмүүжүүлэгч багшийн шагналыг доктор О.Бүрэнжаргал, шилдэг сурган хүмүүжүүлэгч багшийн шагналыг доктор Т.Байгал-Амар, доктор П.Ариунсүрэн нар авсан байна.

Анхаарах асуудал:

- Төрөөс болон сургуулиас судалгааг санхүүжүүлэх байдал хангалтгүй байна.
- Багш бүр төсөл, хөтөлбөрт хамрагдаж судалгааны санхүүжилт олж чадахгүйгээс болж судалгааны ажлаа чанартай хийх, олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд үр дүнгээ хэвлүүлэх боломжгүй байна.

Зөвлөмж:

- Профессорын багууд хамтарч судалгааны санхүүжилт олж, хамтарсан өгүүлэл гаргах.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

5.1 Сургалт, судалгааны орчин

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш, суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт явуулах анги танхим, судалгаа хийх лаборатори зэрэг ажиллах орчин нь зохих шаардлага хангасан байна.
- Орчин үеийн дэвшилтэт технологи хөгжлийн шинэ хандлагад тулгуурлан 26 хичээлийн стандарт хөтөлбөрийг шинэчилж, е-хичээлийн иж бүрдлийг шинэчлэн ашиглаж эхэлсэн байна. Экологийн магистрын хөтөлбөрийн сургалтад лекцийн 4, семинарын 8, сургалт судалгааны чиглэлийн 4 лаборатори ашиглагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 26 хичээлийн стандарт хөтөлбөрийг шинэчилж, е-хичээлийн иж бүрдлийг шинэчлэн ашиглаж эхэлсэн байна. Уг хөтөлбөрийн сургалтанд лекц 4, семинар 8, сургалт судалгааны 4 лаборатори ашиглаж байгаа нь сургалтын орчныг тодорхой түвшинд хангагдсан байна.
- Олон улсын төслийн санхүүжилтээр 2 лаборатори шинээр байгуулсан.

Анхаарах асуудал:

- Ариун цэврийн өрөөний тоо хангалтгүй байна.
- Анги танхим, сургалтын орчинг сайжруулахад оруулах хөрөнгө оруулалт муу байна.

Зөвлөмж:

- Анги танхим тохижуулах, сургалтын орчныг улам сайжруулах талаар сургуулийн зүгээс оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

5.2 Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, магистрантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын өрөө нэг хүнд ноогдох талбай 2017 онд 6.4м² байсан бол 2021 онд 7.7м² болж өссөн нь багш нарын ажиллах орчин нөхцөл дээшилсэн байна. Анги танхимын хувьд 2017 онд 126.2 м² байсан бол 2021 онд 155.1 м² болж хүртээмж дээшилсэн байна.
- Багш нар нь компьютер болон бусад дагалдах хэрэгслэлээр тодорхой түвшинд хангагдсан бөгөөд интернэтийн сүлжээг Ulms программаар шинэчилжээ.
- Оюутнууд онлайн болон зайны сургалтандаа Google classroom платформыг ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Газар зүйн мэдээллийн системийн ArcGIS 10.1-10.8, ArcGis Pro, дүрс мэдээ боловсруулах ENVI 5, SPSS зэрэг программ хангамжуудыг албан ёсны гэрээтэйгээр болон албан бус хувилбарыг ашиглан сургалтын агуулгыг суралцагчдад бүрэн хүргэн ажиллаж байна.
- Экологийн хөтөлбөрт хамрагдаж буй оюутнуудад ArcGIS 10.1-10.88, АНУ-ын E компанийн лицензтэй ArcGIS Pro програмуудыг судалгааны лабораториуд дээр түшиглэн сургалтуудыг хийх боломж бүрдсэн нь Байгаль орчны хөгжлийн технологийн хөгжилтэй мөр зэргэцэн сургалт явуулах боломж бүрдсэн.
- 2018 онд хөрс-агрохимийн лаборатори Монгол улсын стандарт хэмжил зүйн газрын MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлага хангаж магадлан итгэмжлэгдэж баталгаажсан байна.
- 1 оюутанд оногдох 2-12 м² талбай илүү оногдхоор байгаа нь дэлхий нийтийн хамарсан цар тахлын хүрээнд хүн хоорондын зай барихад эрүүл ахуйн шаардлага хангахаар байв.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн 95% нь үндсэн сурах бичигтэй боловч зарим хичээлийн үндсэн сурах бичгийн тоо номын санд харьцангуй бага байна.

Зөвлөмж:

- Ном сурах бичиг бусад хэвлэл мэдээллийн хэрэгслэлд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх хэрэгтэй.
- 2021 онд Агроэкологийн сургуулийн хэмжээнд нийт 6 анги, танхим лабораториудыг танхим лабораториудыг 27.7 сая төгрөгийг гаргаж тохижуулсан нь хангалттай бус тул цаашид санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

5.3 Төсөв, санхүүжилт

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулдаг, үүнд багш нарын саналыг харгалздаг байна.

Илрэл нотолгоо:

- Гадаадын төслийн санхүүжилтээр 214.514.054 төгрөг бүхий хөрөнгө оруулалтыг татаж лабораториудыг тохижуулсан байна.
- ХААИС нь санхүүгийн үйл ажиллагааны дүрэм, журмын дагуу экологийн магистрын хөтөлбөрийн зардлыг бүрэн санхүүжүүлдэг. Сургуулийн төсөвт тэнхимийн саналыг тусган оруулах замаар үндсэн үйл ажиллагаа болон эрдэм шинжилгээ болон нэмэлт үйл ажиллагааг санхүүжүүлдэг.
- Тэнхимүүд бакалавр, магистр, докторын сургалтын төлбөрөөс гадна төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, ном, гарын авлагаас олсон орлого, сургалт, нэмэлт кредитийн төлбөр гэх мэт тэнхимийн бусад орлогоос санхүүжиж ирсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цахим сүлжээнд нэгдэж олон улс, дотооддоо хэрэглээний өндөр боломж нээгдсэн.
- Магистрантын сурахад чиглэсэн төлбөр тогтоолт тогтвортой байна. Харин нэг оюутанд зарцуулах төлбөрийн хэмжээ харилцан адилгүй байна.
- Суралцагчдын сурах орчныг сайжруулахад тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа нь өөрийн үнэлгээний тайлан болон нотлох баримтуудаас харагдаж байна.

Анхаарах асуудал:

- Судалгааны ажилд хөрөнгө мөнгө түлхүү төсөвлөх.
- Багшийн ажлын үнэлэмж сул 1 кредит цагийн хөлс бага байгаа тул цаашид нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- ХААИС-аас буюу дотоодын санхүүжилт дутмаг, судалгааны ажилд хөрөнгө, мөнгө бага төсөвлөж ирсэн байгаа тул санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг бүрдүүлэх талаар анхаарах
- Шинжлэх ухаан технологи асар хурдтай хөгжиж байгаа энэ үед шинээр лаборатори нэмж байгуулах газар зүйн мэдээллийн системийн ArcGIS pro 2.3 программыг ашиглах хүчин чадал, хурд сайтай компьютерээр хангах тал дээр анхаарах.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоотой, захиргааны зохистой бүтэц, удирдлагын мэдээллийн системтэй байна.

6.1 Засаглал ба удирдлага

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Удирдлага мэдээллийн системийн үйл ажиллагаа тогтвортой хөгжиж байгаа бөгөөд нэгдсэн удирдлага зохион байгуулалт зохицуулалтаар хангах сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах талаар ажил тогтворжсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Удирдлага мэдээллийн системийн үйл ажиллагаа тогтворжсон.
- Нэгдсэн удирдлага, зохион байгуулалт зохицуулалтаар хангах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах тал дээр сайн ажилладаг.
- Суралцагч сургалттай холбооотой бүхий л мэдээллийг сургуулийн цахим хаяг болон мэдээллийн бусад эх сурвалжаас түргэн шуурхай авах боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Засаглалын тогтолцооны загварыг боловсруулж хэрэгжүүлэх ажил дутмаг.
- Удирдлагын мэдээллийн системийн давуу талыг ашиглан хөтөлбөрийн үр дүнд дүн шинжилгээ хийх.
- Элсэгчдийн тоо буурах хандлагаас урьдчилан сэргийлж, давуу талаа гарган гарц шийдлийг тодорхойлох.
- Санхүүжилтийн олон талын эх үүсвэр бүрдүүлж, техник технологи, мэдээллийн баазын шинэчлэлт хийх.

Зөвлөмж:

- Элсэгчдийн тоо буурах хандлагаас урьдчилан сэргийлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх буурч болзошгүй эрсдлийг тооцож, цаашид холбогдох арга хэмжээ авч ажиллах

6.2 Ажилтнууд

Захиргааны болон туслах ажилтны орон тоо хангалттай, зохих ур чадвар, туршлагатай байна. Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистр докторын сургуулын удирдлагын үндсэн бүрэлдхүүнээс гадна хөтөлбөрт үйлчилгээ үзүүлдэг бусад багш, ажилтан, албан хаагчид салбар сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хөтөлбөрийн хорооны гишүүд, хөтөлбөрт хичээл заадаг доктор болон түүнээс дээш зэрэгтэй багш нар хөтөлбөрийн нийт ажиллах хүчний багт багтан ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургууль нь АНУ, Канад, Франц, Япон, БНСУ, БНХАУ, ОХУ, Казакстан зэрэг орны их дээд сургуулиудтай эрдэм шинжилгээ сургалтын үйл ажиллагаагаар хамтран ажиллахаас гадна багш ажилтан, оюутан солилцооны хөтөлбөр

хэрэгжүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Багшийн ажлын үнэлэмж сул байна.

Зөвлөмж:

- 1 кредит цагийн хөлсийг нэмэгдүүлэх боломжийг судлах.

6.3 Удирдлагын мэдээллийн систем

Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Удирдлагын мэдээллийн системийн үйл ажиллагаа тогтвортой, жигд нэвтэрсэн
- Хөтөлбөрийн хорооны зүгээс удирдлага мэдээллийн системд үндэслэн хөтөлбөрийг тогтвортой хөгжүүлэх тал дээр тодорхой ажилуудыг төлөвлөн хэрэгжүүлхээр ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Удирдлагын мэдээллийн системийн үйл ажиллагаа тогтвортой, жигд нэвтэрсэн

Анхаарах асуудал:

- Мэдээллийг шинэчлэх, цаг үеийн мэдээ мэдээллээр түргэн шуурхай хангах тал дээр анхаарах.

Зөвлөмж:

- Удирдлагын мэдээллийн системийн давуу талыг ашиглан хөтөлбөрийн үр дүнд дүн шинжилгээ хийх тал дээр анхаарах

6.4 Мэдээллийн ил тод байдал

Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагч сургалттай холбоотой бүхий л мэдээллийг сургуулийн цахим хаяг болон мэдээллийн бусад эх сурвалжаас түргэн шуурхай авах боломж бүрдсэн.
- ХААИС-ийн АЭС-ийн цахим хуудсанд байршдаг бөгөөд захиргаа салбар сургалт оюутан мэдээ мэдээлэл холбоо барих гэсэн цэсүүдээр мэдээ мэдээллийг түгээдэг.
- ХААН кампус хөтөлбөрт олон улсын мэдээллийн сүлжээнд нэгдэх эх үүсвэрүүдийг ашиглах талаар тусгаж, үе шаттайгаар сайжруулах ажлыг зохион байгуулж ирсэн байна.
- Мэдээллийн сангуудыг хэрхэн ашиглах талаар сургалт мэдээллийг МНСК-тай хамтран улирал бүр зохион байгуулж ирсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч сургалттай холбоотой бүхий л мэдээллийг сургуулийн цахим хаяг болон мэдээллийн бусад эх сурвалжаас түргэн шуурхай авах боломж бүрдсэн.

- 2015 онд МНСК-д гишүүнээр элсэн хамтын ажиллагаагаа идэвхжүүлсний үр дүнд эрдэм шинжилгээний өгүүллийн мэдээллийн сан руу ХААИС-ийн сүлжээнээс шууд хамрагдах боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Техник технологийн шинэчлэлт хийх, сүлжээний хурд, мэдээлэл авах эх үүсвэрүүдийн мэдээллийг түргэн шуурхай болгож шинэчлэх.

Зөвлөмж:

- Техник технологийн шинэчлэлт хийх, сүлжээний хурд, мэдээлэл авах эх үүсвэрүүдийн мэдээллийг шуурхай болгох

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

7.1 Дотоод чанарын баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөгчдийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга, тогтмол давтамжтайгаар хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Чанарын удирдлага зохион байгуулалтын алба хөтөлбөрийн чанарт хяналт тавьдаг.
- “Хөтөлбөрийн чанарын менежментийн гарын авлага”-ыг баримтлан ажиллаж байна.
- Экологийн магистрийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын дунд хугацааны төлөвлөгөөг гарган /2021-2024/ ажиллаж байна.
- Жил бүрийн суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч сургалтын процессийг сайжруулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2014 оноос Хөтөлбөрийн хороо байгуулагдан, магистрын сургалтын төлөвлөгөөг сайжруулах ажлыг зохион байгуулж байна.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг сайжруулах хөтөлбөрийн хорооны нэгдсэн зохион байгуулалт, бүтэц тогтолцоо бүрэлдэн тогтсон.
- ХААИС нь 2018 оноос байгууллагын бүтцэд биеэ даасан Чанарын удирдлага, зохицуулалтын алба байгуулан ажиллаж байга нь сайшаалтай.
- 2020 оноос “Хөтөлбөрийн чанарын менежментийн гарын авлага”-ыг баримтлан ажиллаж байна.
- Экологийн магистрын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын дунд хугацааны төлөвлөгөөг гарган (2021-2024) ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Экологийн магистрийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын үр дүнг тодорхой бус байна.

Зөвлөмж:

- Өөрийн үнэлгээнд үндэслэн хийсэн SWOT, TOWS шинжилгээ, хэрэгжүүлэх стратеги, сайжруулах арга замыг цаашид чанарын дотоод баталгаажуулалтын үйл ажиллагаандаа үе шаттайгаар хэрэгжүүлэх.

7.2 Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл

Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн үйл явцад хийх хөндлөнгийн үнэлгээ Магистр, докторын сургуулийн хөтөлбөрийн эрхлэгч, хөтөлбөрийн хорооны зохицуулагч хяналт тавьдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Экологи магистрын хөтөлбөр нь анх удаа магадлан итгэмжлэлд орж байгаа бөгөөд өмнө нь хөтөлбөрийн үнэлгээг магадлан итгэмжлэлийн шалгуураар үнэлж байгаагүй байна.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт

ХААИС-ийн Магистр, докторын сургуулийн Экологи хөтөлбөр нь 2003 оноос үйл ажиллагаагаа эхэлж, нийт 91 магистр зэрэгтэй мэргэжилтнийг бэлтгээд байна.

Бид өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримтуудыг судлан шинжилж, багш, оролцогч талуудын уулзалтын үр дүнд дараах зүйлсийг дүгнэж байна. Үүнд:

1. Экологи хөтөлбөр нь 2003 оноос хойш тогтмол сургалтын үйл ажиллагаа явуулж, хөтөлбөрийн шинэчлэлтүүдээр (2009, 2011, 2015, 2017, 2021) хөтөлбөрөөр олгох мэдлэг, ур чадвар бүрэн шинэчлэгдэж, хичээлийн агуулга тасралтгүй хөгжиж ирсэн. Мөн энэ хөтөлбөр нь оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадвар, дадал олгох зэргээр төгсөгчийн загвараа иж бүрэн боловсруулсан байна.
2. Экологи магистрын хөтөлбөр танхимын сургалт харьцангуй бага цагийг эзлэх тул суралцагчдад судалгаа хийх, төсөл хөтөлбөрт ажиллах, эрдэм шинжилгээний бүтээл гаргах зэргээр магистрантын судалгаа, бүтээлч ажлыг дэмжин ажилладаг бөгөөд энэхүү хөтөлбөрөөр суралцагч магистрантуудын судалгааны ажил тогтмол ХААИС-ийн магистрант, докторантуудын эрдэм шинжилгээний бага хурлаас "шилдэг илтгэл" -ээр шалгарч байна. Бакалаврын төгсөгчдөөс магистрын хөтөлбөрт

үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй оюутан нэлээд байх ба харьцангуй тогтмол элсэлттэй хөтөлбөрт багтдаг.

3. Багшлахуйн үр дүнг сайжруулахын тулд суралцагчдын дунд санал асуулгыг жилд 2 удаа явуулж, сургалтын үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд судалгааны үр дүнгээс үзэхэд суралцагчдын хувьд эрдэм шинжилгээний удирдагчийн үйл ажиллагааг маш сайн гэж үнэлсэн бол эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирлын үйл ажиллагааг сайжруулах, төлөвлөх шаардлагатай гэсэн байв.
4. Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, суралцагчдыг суралцахуйн зорилтоо биелүүлэхэд нь дэмжлэг болгож, боловсролын зээлийн сангаас сургуульд зохих журмын дагуу элссэн, сурлагын шаардлага хангасан, суралцагсдад урт хугацаатай зээлийг олгож байгаа нь суралцах таатай нөхцөлийг бүрдүүлснээс гадна профессор багш нарын төслөөс цалинжуулах, шилдэг илтгэлийн мөнгөн урамшуулал (500.0-1000.0 төгрөг) олгох зэргээр дэмжлэг үзүүлдэг.
5. Экологи хөтөлбөр нь гадаад, дотоодод хамгаалсан 100% докторын зэрэгтэй, ахлах зэргээс дээш албан тушаалд ажилладаг багш нартай бөгөөд багш нар нь гадаад, дотоодын олон төсөл, хөтөлбөрүүдийг удирддаг, гүйцэтгэдэг учраас элсэгчдийг эрдэм судалгааны ажилд татан оролцуулдаг зэргээр суралцагчдыг тогтмол дэмжин хөгжүүлдэг болно.
6. ХААИС-ийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр” хэрэгжүүлж эхэлснээр Экологи хөтөлбөрт хичээл заадаг багш нарын заах арга зүйг чадавхижуулах, гадаадын хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр судалгааны арга зүйг сайжруулах зэргээр магистр оюутны хэрэгцээнд нийцсэн сургалт, судалгаа явуулахад чиглэлд анхаарч тогтмол сайжруулж байна.
7. Сургалт, судалгааны орчныг эрүүл, аюулгүй, судалгаа хийх лаборатори, бөгөөд энэхүү хөтөлбөрөөр элссэн магистрантууд нь бие дааж судалгаа хийх орчноор хангагдсан, мөн удирдагч профессор багш нарын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамрагдан судалгааны ажлаа илтгэх, бүтээлээ хэвлэн нийтлүүлэх боломжтой байдаг.
8. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс сургууль, мэргэжлийн хөтөлбөрийн хороо байгуулагдан, хөтөлбөрийн үйл ажиллагааг шат дараалан явуулж, сургалтанд оролцогсодоос сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч үйл ажиллагаандаа тусгадаг болсон нь хөтөлбөрийг хөгжүүлэхэд ахиц дэвшил болжээ.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	5			Бүрэн хангасан
2	Магистрын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	5			Бүрэн хангасан
3	Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	8			Бүрэн хангасан
4	Багшлах бүрэлдэхүүн	4			Бүрэн хангасан
5	Нөөц ба санхүүжилт	3			Бүрэн хангасан
6	Удирдлага ба мэдээллийн систем	4			Бүрэн хангасан
7	Чанарын баталгаажуулалт	2			Бүрэн хангасан
		31			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө аж ахуйн их сургуулийн Магистр, докторын сургуулийн “Экологи” магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Байгалийн ухаан, математик, статистикийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Д.Нарангарвуу

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Д.Хишигбаяр

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Ю.Дэлгэрмаа

Ерөнхий зөвлөмж

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	<ul style="list-style-type: none"> • Хувийн хэвшлийн ажил олгогчдын төлөөллийн саналыг хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлж, сургалтын төлөвлөгөө боловсруулахад оролцуулдаг байх • Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа авах • Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах • Төгсөгчдөөс мэргэжлийн англи хэл, чөлөөт сонголтын хичээлийн багц цагийг оруулах хүсэлтэйг уламжилж байна. • Байгаль орчны эрх зүй, Байгаль орчны эдийн засаг, Байгаль орчны үнэлгээ аудит хичээлүүд бакалаврын түвшинд байгаа учраас агуулгыг харьцуулан давхцуулахгүй байх, ялгааг гаргах, ахисан түвшинд хүргэх • Мөн эдгээр хичээлүүдийн сурах бичгүүд яг ижил байгааг шалгах, бусад боломжит эх сурвалжийг ашиглах, ашиглах сурах бичиг сайжруулах • Бакалаврын хөтөлбөрт буй хичээлүүдийн давхардлыг багасгах
Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> • Магистрын судалгааны ажлыг санхүүжүүлэх гарц хайх • Хөтөлбөрийн сурталчлааг төгсөгчидөөр дамжуулан сурталчлах • Мэргэжлийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх • Магистрантын судалгааг санхүүжүүлэх гарц хайх • Судалгааны ажлын үр дүнг олон улсын сэтгүүлд хэвлүүлэх боломжоор хангах
Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	<ul style="list-style-type: none"> • Сургалтанд шаардлагатай тоног төхөөрөмж, эм урвалж, багаж худалдан авах боломжийг хайх. • Суралцагчдыг хөгжүүлэх бие даан суралцах анги танхимын тохижуулах. • Ажил олгогч нарын нийтлэг шаардлагын дагуу албан бичиг хөтлөлт, эрх зүй, гадаад хэлний мэдлэг ажлын байранд тавигдах шаардлагыг сайжруулах, • Дадлагажих хугацааг хангалттай болгох. • Магистрантыг амжилттай суралцахад дэмжих, зөвлөх үйлчилгээг өгөхдөө орчин үеийг судалгааны лабораторийн орчин нөхцөлийг бүрдүүлэх • Сургалтын төлбөрөөс үзүүлж буй хөнгөлөлтийг санхүүгийн тайлангийн хөнгөлөлт хэсэгт харуулах, судалгааны санхүүжилтийг тайлагналыг оновчтой болгож, магистрын судалгааны ажилд зарцуулах хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. • Илтгэл, урамшууллаас гадна нийт магистрантуудын судалгаа, туршилт хийх урвалж, багажаар жигд хангах хэрэгтэй. • Элссэн магистрантуудыг төгсгөх, судалгааны чиглэлүүдэд жигд зөвлөх, багшийн ачааллыг жигд болгох.
Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Судалгааны зарим чиглэлүүдэд шинэ боловсон хүчнийг бэлтгэж эхлэх • Багш нарын судалгааны чиглэлтэй холбогдуулан инновац, гарааны компани байгуулж, санхүүжилт олох боломжийг хайх • Багш нар мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд сургуулийн зүгээс үе шаттай арга хэмжээ авах, • Багш нарыг албан тушаалын зэрэглэлээ ахиулахад анхаарах хэрэгтэй. • Профессорын багууд хамтарч судалгааны санхүүжилт олж, хамтарсан өгүүлэл гаргах.

<p>Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт</p>	<ul style="list-style-type: none"> • Анги танхим тохижуулах, сурах орчныг улам сайжруулах талаар сургуулийн зүгээс оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй. • Ном сурах бичиг бусад хэвлэл мэдээллийн хэрэгслэлд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх хэрэгтэй. • ХААИС-аас буюу дотоодын санхүүжилт дутмаг, судалгааны ажилд хөрөнгө мөнгө бага төсөвлөж ирсэн байгаа тул санхүүжилтын олон талт эх үүсвэрийг бүрдүүлэх талаар анхаарах • Шинжлэх ухаан технологи асар хурдтай хөгжиж байгаа энэ үед шинээр лаборатори нэмж байгуулах газар зүйн мэдээллийн системийн ArcGIS pro 2.3 програмыг ашиглах хүчин чадал хурд сайтай компьютерээр хангах талаар анхаарах.
<p>Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем</p>	<ul style="list-style-type: none"> • Элсэгчдийн тоо буурахтай уялдаж хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх буурч болзошгүй эрсдлийг тооцож цаашид холбогдох арга хэмжээ авч ажиллах • Удирдлагын мэдээллийн системийн давуу талыг ашиглан хөтөлбөрийн үр дүнд дүн шинжилгээ хийх тал дээр анхаарах • Техник технологийн шинэчлэлт хийх, сүлжээний хурд, мэдээлэл авах эх үүсвэрүүдийн мэдээллийг шуурхай болгох
<p>Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт</p>	<ul style="list-style-type: none"> • Өөрийн үнэлгээнд үндэслэн хийсэн SWOT, TOWS шинжилгээ, хэрэгжүүлэх стратеги, сайжруулах арга замыг цаашид чанарын дотоод баталгаажуулалтын үйл ажиллагаандаа үе шаттайгаар хэрэгжүүлэх

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог, нэр	Албан тушаал, зэрэглэл	Улсад ажилласан жил	Заадаг хичээл
1	Т.Оюунчимэг	профессор	33	Байгаль орчны эрх зүй, Байгаль орчны аудит, Байгаль орчны эдийн засаг
2	П.Ариунсүрэн	дэд профессор	24	Экосистемийн нөхөн сэргээлт, Бэлчээрийн экологи, хамгаалалт
3	Х.Баярмаа	дэд профессор	28	Судалгааны ажлын төлөвлөлт, бүтээл бичих арга зүй, Агрэкологи
4	О.Бүрэнжаргал	дэд профессор	17	Хүрээлэн буй орчин судлал, Ургамлын экологи, хамгаалал, Байгаль орчны мониторинг, Хамгаалалттай газар нутгийн сүлжээ
5	Н.Цэгмид	ахлах багш	19	Биологийн олон янз байдлын хамгаалал
6	Б.Лхамсүрэн	ахлах багш	16	Хөрсний экологи, хамгаалал
7	Г.Ариунжаргал	ахлах багш	17	Бүлгэмдлийн экологи
8	М.Оргилболд	ахлах багш	3	Хүрээлэн буй орчны микробиологи
9	Ш.Оюунтуяа	сургалтын хөтөлбөрийн эрхлэгч	24	Хэрэглээний уур амьсгал, Сууршлын экологи

II. Оюутны нэрс

№	Овог, нэр	Төгссөн он	Цахим хаяг	Утас
1	Т.Эрхэмбаяр	Суралцаж байгаа	AG22E009@mul.s.edu.mn	86790126
2	А.Хишигсайхан	Суралцаж байгаа	AG22E008@mul.s.edu.mn	91625353
3	Б.Энхбаясгалан	Суралцаж байгаа	AG22E004@mul.s.edu.mn	80882232
4	Э.Дуулал	Суралцаж байгаа	AG22E005@mul.s.edu.mn	89190132
5	Э.Амартайван	Суралцаж байгаа	AG20E218@mul.s.edu.mn	89897041
6	Б.Цоггэрэл	Суралцаж байгаа	AG19E224@mul.s.edu.mn	85153421
7	Р.Мөнхбат	Суралцаж байгаа	AG19E224@mul.s.edu.mn	89796626
8	Н.Жүгдэрнамжил	Суралцаж байгаа	AG21E023@mul.s.edu.mn	88838800
9	Т.Болормаа	Суралцаж байгаа	AG20E029@mul.s.edu.mn	99234599
10	Отгонсүрэн	Суралцаж байгаа	AG21E025@mul.s.edu.mn	88778803

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Цахим хаяг
1	Ц.Дашпүрэв	Хустайн БЦГ дарга	99006006	dashpurev@hotmail.com
2	Б.Удвал	ШУА, Газарзүй геоэкологийн хүрээлэн, Ойн нөөц ой хамгааллын салбарын дарга	99054345	udvalb@mas.ac.mn
3	Г.Энхтоогоо	НЕБЛӨЗБ Ахлах сургууль,	88863246	enkhtogoo.g@uswur1975.edu.mn
4	Ө.Дэмбэрэлням	Дархан ХААИС, СА дарга	88071776	demberelnyam@sab.edu.mn
5	П.Ганхуяг	Монголын шувуу хамгаалах төв төрийн бус байгууллага	88077576	pgankhuyag@gmail.com
6	Ц.Алтанзул	Тогтвортой ноос ноолуур төв, Нар хүрээлэнгийн захирал	96662456	Altanzul.tsevlee@gmail.com
7	Н.Жавхлан	МАК цемент ХХК	89997749	javkhlan.n@mak.mn
8	Б.Өлзийжаргал	Говьхангайн төгөл ХХК захирал	99840401	Uj888999@gmail.com
9	Н.Цэвээнмядаг	Зэрлэг амьтан судлах хамгаалах төвийн тэргүүн	99042804	Tseveen@wscc.org.mn
10	Н.Догсом	ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг	99012847	Dogsom@gmail.com

IV. Төгсөгчдийн нэрс

Д/д	Овог	Нэр	Төгссөн он	Эрхэлж буй ажил	Холбоо барих утас
1	Төртогтох	Ариунболд	2010	ХААИС, МААБС-д багш	99074505
2	Шугарсүрэн	Мандах	2011	Эко үнэлгээ ХХК гүйцэтгэх захирал	90681959
3	Ганбаатар	Ганцэцэг	2012	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, микробиологийн лабораторит ЭША	88083173
4	Сундуйхүү	Сайнбаяр	2012	И СИ ӨУ СИ ТИ ХХК захирал, Тогтвортой ноос, ноолуур эвсэлд шинжээч	88043013
5	Чимэддорж	Догсом	2013	ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар мэргэжилтэн	99012847
6	Хасбаатар	Бадар-Ууган	2015	GIZ орчуулагч, нярав	
7	Онгоодой	Мөнхтуяа	2016	Багануур ХХК, Экологич инженер	99034493
8	Эрдэнэбилэг	Анхбаяр	2020	ХААИС, АЭС, Дендрозокологийн лабораторит лаборант	99022478
9	Баасанжав	Бадамцацрал	2020	ШУТ Сангийн газрын дарга	99995620
10	Батдэлгэр	Оюун-Эрдэнэ	2020	Говь-Хангайн төгөл ХХК-д мэргэжилтэн	88717124
11	Эрхэмбаяр	Үүрцайх	2022	Мейк грийн ХХК-д үнэлгээний мэргэжилтэн	80033366
12	Алтангэрэл	Энхзаяа	2014	ХААИС, Эрдэм шинжилгээний алба, мэргэжилтэн	99287800

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
11 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 243
И-мэйл: agroecology@mul.s.edu.mn
Вэб сайт: www.mul.s.edu.mn

2023.01.11 № 01/04
танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Экологи магистрын хөтөлбөрийн шинжээчийн баг ажиллаж 7 шалгуур бүрээр шинжилгээ хийж 33 ерөнхий зөвлөмж бүхий тайлан ирүүлснийг хүлээн авч танилцлаа.

Шинжээчийн тайланг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд өгсөн зөвлөмжийн дагуу цаашид хөтөлбөрөө сайжруулан ажиллах болно. Тус хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үргэлжлүүлэн явуулж өгнө үү.

ЗАХИРАЛ



А.БУЯНБААТАР

022705003